



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/А31

Булган сум

**Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Зураг төслийн жишиг үнийн дүрэм" БД 81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" XXV/05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтын 2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн "Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах зардлын хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/651 тоот захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Могод сумын Баясгалант 2 дугаар багийн "Иргэдийн хөгжлийн төвийн барилга"-ын зураг төсөв боловсруулах ажлыг 11,850,000 (арван нэгэн сая найман зуун тавин мянга) төгрөгөөр "Зууны гүүр" ХХК-тай гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Зууны гүүр" ХХК-ийн захирал (Х.Дэлгэрмаа)-д үүрэг болгосугай.

3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), Аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д тус тус даалгасугай.

4. Дээрх ажлуудын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

6324011049